

Олон улсад. Эрдэм шинжилгээний хурлын материалаас

# БОДЛОГЫН МЭДЭЭ

POLICY NEWS

AD CURRAM ET COMMUNICO!

2023.11 №22



Улс Төр Судлал,  
Олон Улсын Харилцаа,  
Нийтийн Удирдлагын Сургууль



### Мэндчилгээ

Эрхэм хүндэт уншигч Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Олон улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдрал улам бүр ээдрээтэй болж буй цаг үед бид амьдарч байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахал, түүнийг залган Орос-Украины дайн, эдүгээ Израйль-Палестиний мөргөлдөөнөөс үүдсэн Ойрхи Дорнодын бүс нутгийн хямралт байдал зэрэг үйл явцууд ар араасаа хөвөрч дэлхийн геополитикийн дахин хуваарилалт эргэлт буцалтгүйгээр өрнөж байна. Ийм амаргүй нөхцөлд Монгол Улсын гадаад бодлого эрчимжиж дэлхийн дахины энх тайван, аюулгүй байдлын төлөөх хүчин чармайлтаа олон улсын түвшинд ойлгуулж, хүлээн зөвшөөрүүлж чадсан явдал бол манай гадаад харилцаанд гарсан том ахиц дэвшил, амжилт юм.

Бид энэ амжилтаа бататган хөгжүүлэх үндэс нь гүнзгий мэдлэг, өндөр ур чадвартай үндэсний боловсон хүчнийг улс төр, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын салбарт бэлтгэх явдал гэж үздэг юм. Энэ үүргийг МУИС-ийн холбогдох тэнхимүүд амжилттай гүйцэтгэж ирсэн бөгөөд эдүгээ тус сургуулийн эрхэм зорилго нь уламжлалт үнэт зүйлсийг хадгалан хөгжүүлэхийн зэрэгцээ шинэ мэдлэг, нийгмийн инновацийг бий болгох, судалгаа шинжилгээний үр дүнгээ гадаад, дотоодод түгээх, дэлхийд өрсөлдөхүйц хүний нөөцийг бэлтгэхэд анхаарч байна. Энэ жил МУИС-д бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль нь Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль нэртэйгээр шинэчлэгдэн байгуулагдсан.

Дээр дурьдсан бодлого, зорилгын хүрээнд тус сургуулийн Бодлогын судалгааны төвөөс эрхлэн хэвлүүлдэг уламжлалт бодлогын мэдээгээ үргэлжлүүлэн гаргах болсондоо баяртай байна. Цаашид бодлогын мэдээний хамрах хүрээг өргөжүүлж, агуулгыг гүнгийрүүлнэ. Улс төр, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын орчин цагийн хөгжлийн хандлага, тулгамдаж буй асуудлын талаарх шинэ мэдээ, мэдээллийг шинжлэх ухаанч байр сууринаас тайлбарлан хүргэж байх болно.

Бодлогын мэдээ цувралын энэ удаагийн дугаарт Орос-Украины дайны асуудлыг голлон хөндлөө. Дараагийн дугаараа Ойрхи Дорнодын бүс нутгийн хямралын асуудлаар бэлтгэж Та бүхэнтэй хуваалцах болно.

Эрдэм номыг дээдлэгч эрхэм хүмүүн Таныг номын авшиг үргэлж ивээж байх болтугай

*Улс төр судлал, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн захирал*

*Профессор С.Мөнхбат*

## ОЛОН УЛСАД

МУИС-ОУХНУС-ийн дэргэдэх Бодлогын судалгааны төв, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэн хамтран “Орос-Украины мөргөлдөөн:

Дэлхийн шинэ дэг журам болон Монгол Улсын анхаарах асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулсан билээ. “Бодлогын мэдээ №21”-д уг

хэлэлцүүлгийн эхний 4 илтгэлийг нийтэлсэн бол энэ удаа үлдсэн илтгэлүүд болон хэлэлцүүлэгт оролцсон судлаачдын яриа, мэдээллээс сорчлон сонгож дор нийтлэв. Х.Б.







Р.Нямдаваа

Олон улсын харилцааны судлаач

## ОРОС-УКРАЙНЫ ДАЙН БА АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ

Энэ бүс нутагт эдийн засгийн хувьд нөлөө нь эрс нэмэгдэж байгаа улс орнууд олон байгаа. Тайваниас бусад Азийн орнуудын эдийн засаг ковидын үед унасан боловч, аажимдаа сэргэж байна. Энэ бүс нутаг олон улсын харилцааны төв болж байгаа гэдэг талаас нь харж байгаа. Түүнээс гадна АНУ-ын түнш гэгддэг ардчилсан орнууд олон бий. Мөн уг нутагт их гүрнүүд бага, буурайгаа түрэмгийлж болдог гэсэн жишиг тогтохоос эмээж байгаа жижиг улсууд ч байна.

БНХАУ-ын эрх баригч Хятадын коммунист намын Төв хорооны гадаад харилцааны хэлтсийн дарга Ван И ОХУ-д айлчиллаа. Энэ үеэрээ Украинд энх тайвныг тогтоох тухай, БНХАУ-ын санаачлагын талаар ярьж эхэллээ. Үүнийг Оросын талыг дэмжигчид болон Барууны талд зогсогчид өөр өөрсдийн өнцгөөс тайлбарлаж байна.

Улс орнууд олон улсын харилцааны одоогийн системд сэтгэл хангалуун ба хангалуун бус гэж хоёр ангилалд хуваагддаг. Орос, Хятад хоёрын аль аль нь сэтгэл хангалуун бус байгаа учраас Украин дахь дайны хувьд нэг тал биш юмаа гэхэд өрнөж буй том геополитикийн сөргөлдөөнд бол нэг тал гэдгийг ойлгох ёстой.

Нөгөө талаараа Хятадын гадаад бодлого бол туйлын прагматик бодлого. Гадаад бодлого хэлбэрийн хувьд ямар байх, хэнтэй нөхөрлөх

нь хамаагүй, гадаад бодлогын ашиг сонирхлоо хангаж л байх ёстой. Ийм нөхцөлд бид БНХАУ-ыг Украины асуудлаар Оросыг бүрэн дэмжинэ, эсвэл Барууны шахалтаар Оросын эсрэг зогсоно гэж харах нь гэнэн үйлдэл болно. БНХАУ-ын эрх ашиг юу байгаа вэ гэдгийг бид харах хэрэгтэй. Дайнаас өмнө БНХАУ тун удахгүй АНУ-ыг гүйцэж, дэлхийн тэргүүлэгч гүрэн болно гэдэг хүлээлттэй байсан. Гэтэл тайван замаар явж байсан системийн өөрчлөлтийг Орос-Украины дайн бүхлээр нь өөрчилсөн. Тэгэхээр мэдээж том зургаараа бол одоогийн олон улсын харилцааны системд сэтгэл хангалуун бус байгаа учраас Оростой нэг тал хэдий ч Украины асуудал дээр өөрсдийн эрх ашиг хангагдах ёстой гэсэн байр суурийг нь харах хэрэгтэй.

Японы хувьд 80 гаруй жил үргэлжилсэн Орос-Японы энхийн хэлэлцээ үндсэндээ хийсвэр зүйл болсон. Орост хориг арга хэмжээ тавих асуудлаар НҮБ-д санал хураахад АНД-н улсуудын дийлэнх нь төвийг сахисан байдалтай байсан. Харин хамгийн түрүүнд Оросын эсрэг хоригт хүчтэй нэгдсэн улсуудын тоонд Япон, БНСУ, Шинэ Зеланд зэрэг улс орсон. Хоригт хамгийн хүчтэй нэгдсэн долоогийн бүлгийн гишүүн Япон учраас Япон-Оросын газар нутгийн маргаан ойрын хугацаанд шийдэгдэхээргүй болж байна гэж үзэж болно.

Өмнөд Хятадын тэнгист Зүүн Өмнөд Азийн ардчилсан орнууд болон БНХАУ-ын хооронд мөргөлдөөн үүсэх эрсдэл бий. Өнгөрсөн хоёрдугаар сард БНХАУ-ын эргийн харуулын хөлөг онгоц Филиппиний эргийн харуулын онгоц руу цэргийн зориулалттай лазер тусгасан гэсэн явдал болсон. Олон улсын харилцааны одоогийн жишгээр их гүрэн бол НҮБ-ын гишүүн бүрэн эрхт бусад, өөрөөс нь буурай улс руу цэргээ оруулж болох юм байна гэдгийг бүгд харж байгаа. Үүнийг зөвхөн ОХУ ойлгуулсан юм биш, олон жилийн туршид байсан бодит ойлголт. Өмнөд Хятадын тэнгисийн маргаан ч мөн зэвсэг ашиглах хэмжээнд хүрчих юм биш биз гэсэн асуудал дахин сөхөгдөөд байна.

АНУ-Хятадын харилцаа муудах нь цаг хугацааны асуудал байсан. Түүхийн туршид глобал их гүрэн шинэ гарч ирж буй гүрэнтэй сөргөлдсөн 15 удаагийн тохиолдол байдаг. Эдгээрээс 9-д нь дайн, зэвсэгт мөргөлдөөн гарч байсан. Тэгэхээр ямар ч байсан АНУ, Хятад хоёр одоогоор манлайллын төлөө өрсөлдөж, сөргөлдөж байгаа гэдэг нь бодит ойлголт.

Дүгнэж үзвэл Орос-Украины асуудал АНД-н бүс нутагт жижиг улсуудын хувьд маш эрсдэлтэй байдлыг үүсгэсэн. Ялангуяа Өмнөд Хятадын тэнгис болон бусад маргаантай хэсгүүдэд том нь жижгээ хүчээр түрж болдог

гэсэн жишгийг бий болгож байна.


Бүс нутгийн чухал гүрэн болох ОХУ болон Япон улсын харилцааг онцгой муутгалаа. Үүнийг дагаад арлуудын маргаан

ойрын хугацаанд шийдэгдэхгүй гэсэн таамагт хүргэж байна.


Ерөнхийдөө бүс нутгийн жижиг улсууд гадаад бодлогын сорилттой тулгарч байна. Дийлэнх улс нь түдгэлзсэн байр

суурьтай, арай олонх нь Оросын үйлдлийг буруушааж байгаа бол тууштай дэмжиж байгаа ганц улс нь Умард Солонгос байна.

### Asia Pacific's Exports to Russia and Ukraine (% of total)



Source: Citibank. As at 28 February 2022.



**Н.Соёлгэрэл**  
ССХ, судлаач

## ОРОС-УКРАЙНЫ МӨРГӨЛДӨӨН: МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Юуны өмнө энэ үйл явц маань дэлхийн 2-р дайн, ялангуяа ЗХУ-ын 1990-ээд оны задралаас хойш дэлхийн геополитик, олон улсын харилцаанд гарч буй томоохон тектоник шилжилт хөдөлгөөний нэг гэж геополитикийн эрсдлийн шинжээчид дүгнэж байгааг тэмдэглэе. Үүний өмнөх 9-р сарын 11, Иракийн дайн, одоо Украины дайн гм. Тэгэхээр энэ нь олон улсын харилцаа, геостратеги, гео-эдийн засаг, Их гүрнүүд гэлтгүй жижиг улсуудын бодлого, үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх явц вэ гэдэг нь ойлгомжтой харагдах болов уу.

Украйн, Орос хоёрыг олон улсын тавцанд дэмжиж буй улсуудын дүр зургийг харвал хол зөрөөтэй. ОХУ-ын батлан хамгаалах зардал өндөр хувиар өсөж байгаа боловч өрнөдийн тэргүүлэх орнууд буюу АНУ-ын батлан хамгаалах салбарын 800 гаруй тэрбумын зардалтай харьцуулахад үүний ердөө 10%-тай тэнцэж байгааг тэмдэглэмээр байна. Үндсэн нэг асуудал бол Орос-Украины дайны улмаас олон улсын, ялангуяа бүс нутагт ямар өөрчлөлтүүд гарч байна вэ гэдэг асуудал юм. Бүс нутгийн болон хөрш улсуудад бодлого, стратегийн томоохон өөрчлөлтүүд ажиглагдаж эхлэж байна. Цаашдаа ч ажиглагдана. Мөн дамжин өнгөрөх тээврийн асуудал, АНУ, өрнөдийн ашиг сонирхол нэлээн гүнзгий орж ирж буй байдал, цагаачдын урсгал, худалдаа, экспорт гэх мэт бүс нутгийн хүрээнд олон

өөрчлөлтүүд гарч ирж болно. Том тойргоор, дэлхий дахинд ямар нөлөө үзүүлж байна вэ гэхээр дэлхийн дэг журамд нөлөөлж буй асуудал нь магадгүй шинэ төмөр хөшиг бий болж байна уу, хангамж-нийлүүлэлтийн сүлжээ тодорхойгүй шинэ эрин үе эхлэж байна уу, эрчим хүч, хүнсийн хангамж маань юу болох нь вэ гэх мэт олон асуултыг дэвшүүлж байна. Энэ хангамж нийлүүлэлтийн сүлжээ бол зөвхөн олон улсын харилцаа төдийгүй бүс нутгийн хэмжээнд ч ажиглагдаж байна. “Эдийн засагт дайны үзүүлэх нөлөө нь Европт эрчим хүчний хямралаас үүссэн хүйтэн байшингаас эхлээд Африкийн хүнсний захуудад хүртэл мэдрэгдэж байна” гэсэн нэгэн тодорхойлолт их сонирхолтой. Бодлого, стратегийн өөрчлөлтийн хувьд зэвсэглэлээр хөөцөлдөх үйл явцыг өөгшүүлж байгаа ийм үйл явдал болж байна.

Монгол улсад хэрхэн нөлөөлж буйг харахын тулд бид нартай зарим талаараа төстэй улсын байдлыг харахгүй байж болохгүй. Монголтой арай төстэй гэх үүднээс Нордик, Балтийн орнууд, Славян, Өмнөд Кавказ, Төв Азийн 4-5 орнууд дээр тус бүрийн кэйсийг харая. Жишээ нь, Финландын парламент өчигдөр санал хураан 184 гишүүн буюу үнэмлэхүй олонхийн саналаар НАТО-д элсэх шийдвэрээ дотооддоо баталгаажуулаад байна. Молдав бол Оросын хөршүүдээс хамгийн

их хохирол амссан улс гэж тооцогдож байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Москвагаас хийн нийлүүлэлт хэд хэдэн удаа тасалдаж, эрчим хүчний үнэ өсч, инфляц нэмэгдэж, үүний зэрэгцээ засаглал буюу Москвагийн дэмжлэг бүхий улс төрийн хүчнээ гаргаж тавих гэсэн оролдлого гарлаа гэсэн шинжээчдийн дүгнэлтийг санаж байгаа байх. Казахстаны хувьд түүхий нефтийн хоолойг нь Орос хэд хэдэн удаа хааж эрсдэл учруулсан. Мөн Оросоос гарч буй гадны компаниудын хөрөнгө оруулалтын урсгалыг өөртөө шингээн, зарим компаниуд нь Казахстанд бэхжээд авсан гэж үзэж байна. Армен, Азербайжаны тухайд Frozen conflict буюу царцсан байнгын, ужгирсан зөрчлүүд дээр, ялангуяа уулын Карабахын асуудал дээр ганц тоглогч нь Орос байсан бол Өрнөдийн анхаарал орж ирсэн. Оросын хөрш улсуудад зөвхөн Оросоос гадна Өрнөдийн болон бусад хөгжингүй орнуудын ашиг сонирхол шинээр орж ирэх нөхцөл байдал харагдаж байна. Гүржийн тухайд Оросоос гарч буй иргэд хамгийн ихээр очиж суурьшсан, 1.5 сая орсон, яг тоо нь тодорхойгүй гэж Гүржийн эх сурвалжаас мэдэгдсэн.

Энэ бүхнээс үндэслээд Монгол улс өнөөдөр ямар байх вэ гэвэл: 2023 онд дэлхий дахины аюулгүй байдлыг ямар байх талаар гаргасан зураглал бий. Энэ зураглалаар улсуудыг 10 бүлэгт хуваахад Монгол улс дундаас

дээгүүр түвшний эрсдэлтэй хэмээн эрэмблэгдсэн. Үүнийг тухайн агентлаг тайлбарлахдаа, хойд талаараа 3500 км гаруй хуурай замаар хиллэдэг хөрш улс маань Украйны дайны гол оролцогч байгаатай холбосон. Аливаа улс орон гадны аюулд өртөмтгий, эрсдэлтэй байхын нэг хүчин зүйл нь хуурай замын урт хил байдаг гэсэн шинжээчдийн дүгнэлт байна.

Манай улсад Орос-Украйны дайн хэрхэн нөлөөлж байгаа нь их өргөн хүрээний асуудал. Ерөнхийд нь 5 бүлэгт хуваахыг зорьлоо. Улс төр-гадаад бодлого, эдийн засаг- худалдаа, тээвэр-харилцаа холбоо, хүмүүнлэгийн салбар, иргэд-нийгмийн оюун санаа гэж бүлэглэн авч үзэж болно.

Улс төр-гадаад бодлогын тухайд гэвэл улс төрийн шийдлийн тулгалт ирж болзошгүй, хоёр талын харилцаанд өөрчлөлт гарч болзошгүй. Гадаад бодлогын бие даасан, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт бодлогод нөлөө үзүүлэхүйц сорилт болж чадах уу, батлан хамгаалах салбар буюу гуравдагч хөрштэй хөгжүүлж буй цэрэг-батлан хамгаалах хамтын ажиллагаа, ялангуяа энхийг сахиулах үйл ажиллагаан дахь оролцоо, олон улсын тавцан дахь нэр хүндэд яаж нөлөөлж байна вэ? Манай НҮБ-ын санал асуулгад хэд хэдэн удаа илэрхийлж буй байр суурийг хоёр өнцгөөс тайлбарлаж болох юм. Нэг талаас нон-актив бодлого гэж олон улсад үнэлэх шинжээчид байж болно. Нөгөө талаас энэ бол Монгол Улсын бие даасан бодлого явуулж буйн илрэл гэж ч тайлбарлаж болох юм гэж бодож байна.

Эдийн засаг-худалдааны хувьд, банк- санхүүгийн салбарын хувьд

гадаад гүйлгээ, төлбөр тооцоонд маань Оросыг “Swift” системээс гаргасантай холбоотойгоор үүсч болох нөлөө. Мөн хоёр талын худалдаанд харьцангуй эерэг дүр зураг ажиглагдаж байгаа ч гэсэн хамтарсан төслүүдийн хувьд тодорхойгүй байна гэж би дүгнэж байна. Жишээ нь, гуравдугаар цахилгаан станцын шинэчлэлийн асуудал, үүнд хэрэгтэй тоног төхөөрөмж нийлүүлэх, хил, гаалиар орж ирэх асуудал. Өрнөдийн хоригтой холбоотой зарим бүтээгдэхүүн нь хоёрдмол зорилгоор ашиглах бүтээгдэхүүнд орсон байх жишээтэй. Тиймээс эрчим хүчний хамаарлыг бууруулах чиглэлээр цахилгаан станцын шинэчлэлд дараагийн шинэ түнш хайх гэх мэт стратеги боловсруулж байх нь зүйтэй. Шатахуун нийлүүлэлтийн хувьд нэлээн эерэг үр дүн гарсан. Өнгөрсөн онд Владивостокт болсон хурлын үеэр ОХУ-ын Ерөнхийлөгчтэй манай Ерөнхий сайд уулзан 2027 он хүртэл АИ-92 бензин тогтвортой нийлүүлэх, дизель түлшийг 10%-ийн хямд үнээр нийлүүлэх гэсэн тогтвортой байдлын гэрээ байгуулаад байна. Хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын тухайд Оросоос манайд ирж буй сонирхлыг алдаж болохгүй. Бид хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцахаа гадаад бодлогодоо тусгаад, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэг улсаас орж ирэх гадны хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтын 1/3-ээс хэтрэхгүй гэж заасан боловч өнөөдөр Хятадын хөрөнгө оруулалт үлэмж их байна. Магадгүй Оросын зүгээс манай улсыг сонирхох явдлыг идэвхтэй ашиглаж оновчтой тооцоолох хэрэгтэй болов уу. Аялал жуулчлалын хувьд маш их сонирхол татна. Нэг жишээг

дурдахад цагаан сарын өмнө ОХУ-ын аялал жуулчлалын 100 гаруй компани Монгол улсад хоёр талын форумыг зохион байгуулсан. Үүгээр маш олон зүйлсийг тохирсон. Оросын 30 гаруй мэдээллийн хэрэгсэл Монгол улсыг нааштайгаар, эерэгээр сурталчлах амлалт үүрэг аваад буцсан. Цаашлаад аялал жуулчлалын салбар нэлээн эерэг байх явц төсөөлөгдөж байна. Энд бас нэгэн хүчин зүйл гарч ирж байна. Хоёр жилийн томоохон хоригийн дараа Хятад хоригоо цуцласан нь Монгол улсын аялал жуулчлалын салбарт тодорхой хэмжээний нөлөө үзүүлж болох юм.

Тээврийн салбарын хувьд ЕХ-оос нийлүүлэх тээвэр, транзит тээвэр саатсан. Дээр нь татварын асуудлууд, даатгалын асуудал нэлээн хүчтэй яригдаж байна. Ялангуяа агаарын тээврийн урсгал төлбөр тооцооны асуудал, агаараар дамжин өнгөрөх байдал нэлээд хомс болсон нь тодорхой хэмжээний нөлөө үзүүлнэ. Мөн авто болон төмөр замын тухайд дамжуулах хоолойг 2029 онд гэхэд дуустахаар тохирсон боловч хэрхэн, яаж явахыг бид харах ёстой болж байна. Автозам дээр сонирхолтой зүйл байгаа. Ерөнхийлөгч Путины тавьсан илтгэлд Москва-Казахстан чиглэлийн хурдны автозамыг сунгаад Хятад, Монгол руу ойртуулж болох юм гэсэн төсөөлөл ярьсан. Бидэнд бас анхаарах асуудал болж байгаа юм.

Мөн нийгэм хүмүүнлэгийн салбарт оюутан солилцооны тухайд квотоо нэмж, харин эсрэгээрээ дайны улмаас Украйнд суралцаж байсан оюутнууд эргэж ирсэн. Нэг талдаа нэмэгдэж байхад нөгөө талдаа хасагдаж байна. Иргэдийн зорчих урсгалд нөлөө үзүүлж

байна. Нийгмийн тогтвортой байдалд энэ нь алсдаа бодох асуудал юм. Сүүлийн үед иргэд, нийгмийн оюун санааны хувьд талцах, ялангуяа социал дээр талцахыг нэг жилийн хугацаанд бид хангалттай харлаа. Социал медиа, fake news, сүүлд л гэхэд Жуковын хөшөөг эвдлээд фотешоп хийгээд оруулсан гэх зэргийг дурдаж болно.

Иргэдийн урсгалын хувьд Хил хамгаалах ерөнхий газраас авсан мэдээ бий. Оросоос хилээр нэвтэрсэн иргэдийн тоо илт нэмэгдсэн. Иргэд, нийгмийн оюун санаанд дайн хэрхэн нөлөө үзүүлж байна вэ гэдэг судалгааг авч үзвэл 2010 оноос хойш Оросын эсрэг хандлага 2022 гэхэд нэмэгдсэн, харин Орост эерэг хандлага бага зэрэг буурсан байгааг бид харж болно.

Монгол улсад, бидний гадаад бодлого, улс төр, өдөр тутмын амьдралд Орос-Украины дайны үзүүлж буй нөлөө, цаашид юунд илүү анхааралтай, сэрэмжтэй, мэдрэмжтэй байх ёстой вэ гэвэл VUCA орчин буюу тодорхойгүй, тогтворгүй, ээдрээтэй ийм орчинд хүн төрөлхтөн амьдарч байна. Үүнтэй уялдуулан үзэл бодол, баримтлал, бодлогоо эргэн харах шаардлага үүсч болох вий гэсэн дүр зураг байна.

Жишээ нь, Frozen conflict дээр өрнөдийн сонирхол шинээр орж байгаа нь томоохон хэмжээний бодлого, стратегийн сонирхолын өөрчлөлт, шилжилт явагдаж байгааг харуулж байна. Тиймээс дэлхийн нэг эд эс, хэсэг гэдэг утгаараа манай бүх бодлого тодорхой, тогтмол байх ёстой юу гэдэг асуудал гарч ирж байна. Харин дайн үргэлжлэх хугацаанд түдгэлзсэн байр сууриа хадгалах нь зүйтэй гэж судлаачийн хувьд би үзлээ. Дайн үргэлжлэх хугацааны хувьд өнгөрсөн 8-р сард НАТО-ийн командлагч асан James G. Stavridis-ийн тодорхойлсноор хамгийн бодит дүн шинжилгээ гарсан гэж би бодож байна. Орос-Украины дайн яаж төгсөх вэ гэж та бодож байна гэх асуултад “Энэ бол Солонгосын дайны нэгэн адилаар төгсөнө. Хамгийн боломжтой хувилбар хүртэл гал зогсоож энхийн хэлэлцээрт хүрч чадахгүй” гэсэн таамаг дэвшүүлсэн. Үүний зэрэгцээ бид энхийг эрхэмлсэн гадаад бодлого, гуравдагч хөршийнхөө итгэлийг алдахгүй, дайныг аливаа байдлаар шүүмжлэх нь зүй ёсны хэрэг. Ингэхдээ бид заавал Кремлийн бодлогыг буруутган хэлэх шаардлага байна уу гэдгийг бодох ёстой. Нэг улсаас хэт хамааралтай салбар,

стратегийн бүтээгдэхүүн, нөөцийн хараат байдлыг бууруулах чиглэлд анхаарах. Энэ нь ганц манай улсад биш дэлхий дахинд тулгамдаж буй асуудал. Магадгүй хамгийн амжилттай байгаа нь мэдээж технологи, мөнгө сайтай гэдгээр ЕХ байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Оросын эрчим хүчний салбараас хараат байдлаа бууруулах чиглэлд хамгийн дорвитой алхам хийсэн. Ирэх 5 жилд бараг 100% энэ хамаарлаас гарах зорилго тавиад явж байна. Хэдий бид тэдгээр улсууд шиг мөнгө санхүү, технологи сайтай биш ч гэсэн ямар нэг байдлаар өөрсдөө одооноос идэвхтэй ажиллах ёстой.

Дараагийн нэг асуудал нь гуравдагч хөршийн бодлогыг бид харин ч маш идэвхтэй ухаалаг авч явах ёстой. Магадгүй манай гуравдагч, хоёрдогч хөршийн хооронд гарсан зөрчлийн үед зөрчил багатай өөр хөрштэйгөө хамтын ажиллагаагаа түлхүү идэвхжүүлээд явах нь чухал. Хөрөнгө оруулалт, эдийн засгийн тухайд гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтыг хийн хоолой, автозам руу татах зэрэг асуудлууд байна.



## Б.Отгонсүрэн

ССХ, судлаач :

Хятадын гадаад харилцааны яамнаас 2 сарын 21-нд гаргасан Украины хямралыг улс төрийн аргаар шийдвэрлэх Хятадын байр суурь баримт бичгийн агуулгыг танилцууля. Энэ мэдэгдлийг ярихын өмнө Хятадын Гадаад харилцааны яамнаас “Даян дэлхийн аюулгүй байдлын санаачлага” хэмээх баримт бичиг гаргасныг санах хэрэгтэй. Энэнь 2022 онд Ши Жин Пин даргаас Баогийн чуулганд дэвшүүлсэн санаачлагын дэлгэрэнгүй албан ёсны баримт бичиг гэдэг онцлогтой. Өөрөөр хэлбэл дайнтай холбоотой аливаа асуудал, улс хоорондын зөрчил мөргөлдөөнийг энхийн замаар шийдэх зарчмыг Хятад тууштай баримтлана гэж заасан. Баримт бичигт мөн 20 салбарт уламжлалт болон уламжлалт бус аюулгүй байдлын чиглэлээр 2 болон олон талын шугамаар хамтран ажиллах тухай дурдсан. Тухайлбал: ШХАБ, Азид хамтын ажиллагаа бэхжүүлэх бага хурал, Хятад ба Төв Азийн 5 улс, Зүүн Азийн холбоо, хамтын ажиллагааны форматуудын хүрээнд бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг тогтоох чиглэлээр хамтран ажиллана гэдгээ нотолж, ОХУ-д ажиллах үеэрээ санал нэгдсэн байгаа. Энэ баримт бичгийн гол зарчим концепц дээр тулгуурлаад Украины мөргөлдөөнийг улс төрийн арга замаар шийдвэрлэх Хятадын байр суурийг ийнхүү гаргажээ. Энийг Хятадын шинэ Гадаад хэргийн сайд олон нийтэд танилцуулсан. Энэ мэдэгдэл 12 зүйлтэй. Улс орнуудын газар нутгийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг хүндэтгэе, дайны галыг зогсооё, яриа хэлэлцээг эхлүүлэе, хүмүүнлэгийн хямралыг

шийдвэрлэе, стратегийн аюул заналыг бууруулах буюу цөмийн зэвсэг хэрэглэх хэрэглэхээс заналхийлэхгүй байя, бактериологийн зэвсэг хэрэглэхгүй байя, хямралын дараа бүтээн байгуулалт хийе гэж улс орнуудыг уриалсан. Энэ чиглэлээр Хятад дайны дараах бүтээн байгуулалтанд оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Энэ баримт бичигт дайн гэсэн нэр томъёолол хэрэглэхгүй, Орос халдан түрэмгийлсэн гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Дээр дурдсан хоёр бичиг баримтанд Украины хямрал гэж дурдсан. Энэ 12 зүйлтэй баримт бичиг гарсантай холбогдуулан АНУ, Герман, НАТО-гийн зүгээс тайлбар хийсэн. Нэгдүгээрт, Хятад нь улс орнуудын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэнэ, НҮБ-ын дүрмийг хүндэтгэнэ, олон улсын эрх зүй, дэг журмыг хүндэтгэнэ гэж буй боловч НҮБ дээр санал хурааж Оросыг Украинаас цэргээ гаргахыг шаардсан тогтоол батлах дээр түдгэлзсэн байр суурьтай байгаа нь үг, үйлдэл хоёр нь зөрж байна гэж үзсэн. Оросыг халдан түрэмгийлэл үйлдсэн гэж хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь улс төр, эдийн засгийн хувьд Оросыг хайцаалсан, бөөрөнхийлсэн агуулгатай, хямралыг намжаах, дайн зогсооход бүтээлч үр дүнтэй санаачлага гэдэгт эргэлзээтэй гэсэн байр суурь илэрхийлсэн.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хэвлэлийн төлөөлөгчийн зүгээс стратегийн ангиллын зэвсэг бууруулах буюу цөмийн зэвсэг бууруулах чиглэлд Хятад ерөнхийдөө зөв чиглэл рүүгээ явж байгааг харуулж

байна гэх байр суурийг эхний саруудад илэрхийлжээ. Аливаа зөрчил мөргөлдөөн гарахад хэн нэгэн хонх дуугаргах ёстой. Хятад бол хонхчны байр суурийг илэрхийлэхэд бэлэн байна гэсэн хандлага ажиглагдаж байна.

Хятадын зүгээс дээрх баримт бичгүүдийг яаран гаргаж байгаа нь дотоод, гадаад олон хүчин зүйлтэй холбоотой байж болох юм. 3 жилийн хатуу хөл хорионы оновчгүй бодлогын улмаас орон нутгийн хэтийдсэн эрх мэдэл, хүний эрхийн мэдрэмжгүй бүдүүлэг арга хэмжээнүүд, эдийн засаг суларсны улмаас залуучуудын ажилгүйдэл ихэссэн, Хятадын Коммунист намын бодлого шийдвэрийг эсэргүүцсэн чинээлэг өндөр хөгжилтэй мужуудын оюутнуудын жагсаал, ахмад настнуудын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын бодлогыг эсэргүүцсэн жагсаал цуглаан ихэссэн буюу нийгмийн зөрчил тэмцэл хурцдах хандлагатай байгаа учраас дотооддоо тогтвортой байдлаа хангах чиглэлээр сорилттой тулгарч магадгүй. Нөгөө талаас Хятадын эдийн засаг Оростой харьцуулахад илүү глобалчлагдсан, дэлхийн том эдийн засгууд харилцан хамааралтай байдаг учраас Өрнөдийн стратегийн түншүүдээ эмзэглүүлэхгүй байх, мөн Оросыг аливаа хэлбэрээр дэмжсэн гэсэн шалтгаанаар барууны санхүү эдийн засаг, технологийн хориг арга хэмжээнээс зайлсхийх сонирхолтой байгаа. Сүүлийн жилүүдэд АНУ бодлогын баримт бичгүүддээ Хятадыг геополитикийн гол аюул занал гэж нэрлэж ирсэн учраас Хятадын Даян дэлхийн аюулгүй

байдлын санаачлага баримт бичиг болон Украины хямралыг намжаах мэдэгдлийн агуулгаар Хятад энхтайван яриа хэлэлцээр, хүмүүнлэг гэсэн ёс суртахууны

үнэт зүйлсийг эрхэмлэсэн олон улсад хариуцлагатай, энх тайвныг эрхэмлэсэн, хамгаалсан улс орнуудыг яриа хэлэлцээнд уриалдаг, зуучилдаг

хариуцлагатай их гүрний presitge үүсгэх гэж байна гэж харж байна.

## Я.Батсуурь

ОУХ судлаач, МОСААХ

Манай улс, нэгдүгээрт, яг өнөөдрийн үүссэн нөхцөл байдлыг ашиглаад өөрийнхөө асуудлыг шийдвэрлэх бодлого баримтлах ёстой. ОХУ-ын байдал ийм байна гээд өрөвдөөд, найр тавиад байж болохгүй. Шууд баруун, зүүн гараараа нефтийн үнэ, эрчим хүчний асуудал, төмөр замын транзит тээврийн асуудал, гурван улсын транзит тээвэр гэх мэт бүх асуудлаа шийдүүлэх алтан боломж гэж харж байна. Нэг жишээ дурдахад, 2000 оноос өмнө АНУ Монголд тусладаггүй байсан. НУБ-ын шугамаар 10 орчим сая доллар өгдөг, тэрийгээ их юм гэж боддог байсан. 9-р сарын 11-нд болсон үйл явдлаас хойш АНУ-ын байр суурь 100% эргэсэн. Манайд

энхийг сахиулагчдыг явуулаач, холбоотон болооч гээд, Иракийг хий бөмбөгдөөд олон улсад нэр хүнд нь унаад байх үед бидэнд хандах үед нь бид баруун, зүүн гараар гэгчээр тэр асуудлыг шийдсэн. Энэ бол сүүлийн том жишээ. Ийм үед нь бид ОХУ-тай зүүн, баруун гараар ярилцаад асуудлуудаа шийдүүлж авах нь алтан боломж гэж хэлэх гэсэн юм. Хоёрдугаарт, ямар ч дайныг дагаж мэдээллийн дайн явдаг. Халх голын дайны үед онгоцоор хашхираад явдаг байсан. Энэ дайнд мөн адил маш том мэдээллийн хохирогч нь Монголчууд бид болоод байна. Дайн эхэлсний дараа олон нийтийн сошиал мэдээллээр 100% байр суурь өөрчлөгдөж байна. Өнөөдрийн илтгэгчид

хүртэл хоёр хуваагдсан байна. Монгол улсад бүх түвшинд дайны талаар нэгдсэн нэг байр суурьтай байх ёстой. Энэ тал дээр эрдэмтэн мэргэдийн байр суурь маш чухал.

Манайд нөлөөлөх чиглэл, салбар тус бүрээр анализ, дүн шинжилгээ хийж үзэх ёстой юм байна гэж үзэж байна. Манайх шиг улсын хувьд эдийн засгийн чадамж, эдийн засгийн гэсвэрлэх чадамжаа нэмэгдүүлэх тал дээр гадаад бодлого, аюулгүй байдлынхаа бодлоготой холбож тодорхой гаргаж явахгүй бол Украины байдлын жишээнээс харахад эдийн засгийн гэсвэрлэх чадвар байдаг юм байна гэдэг нь харагдаж байна.

## Н.Тулга

ОУХ судлаач, ГХЯ

Орос-Украины дайн энэ жилдээ дуусна. Энэ дайн удаан явж чадахгүй гэдэг нь 1-2 профессорын нүүр номны эхний хуудсаас л харагдаж байгаа. Жилд 150,000 хүн амь үрэгдсэн. 3 дахин илүү шархдсан, 600,000 гаруй цэрэг байхгүй болсон. Оросууд Украин руу 240,000 цэргтэй орсон. Анх орсон хүмүүс нь байхгүй болсон. Одоогийнх нь дайчилгааны хүмүүс. 9 сараас

хойш дайчилгаа явуулсан. 1/3 нь дайны талбарт очсон. 2/3 сургалтын цикл дээрээ байгаа. 13000 танктай байснаас 3000-г алдсан. Орос ялагдана. Тун удахгүй. Украин ялна гэдэг нь тодорхой. Тэрний дараа Орос яах вэ гэдэг сценариудыг бид бодох ёстой. Одоогийн хил хязгаартаа үлдээд ямар засагтай байх вэ. Орос задарвал яах вэ гэдэг асуудал байна. Орос

задрахад бид ямар байхаас гадна Хятад яах вэ гэдэг байна. Хятад хар тамхины 2-р дайнаас өмнө эзэмшиж байсан хотуудаа Хятадаар бичээд эхэллээ. Бид нараас авсан газар нутаг 1.5 сая км. гээд. Орос задрахад Хятад эргээд авна. Цаашлаад Чин улсын газар нутгаа сэргээн гэсэн үзэл гээд харах, үзэх зүйл их байна.

**Ц. Дэмбэрэл**

ОУХ судлаач, МОСААХ

Ганц Украины дайн биш, олон улсын харилцааны бүх асуудал 6 зүйл дээр төвлөрөх ёстой. Нэгдүгээрт: үндэсний эрх ашиг, үүнд Оросын эрх ашиг, Украины эрх ашиг яаж хөндөгдөх вэ гэдэг асуудал. Дараагийнх нь: геополитикийн асуудал. Гуравдугаарт: үндэстний асуудал. Дөрөвдүгээрт: хөдөлмөрийн хуваарь буюу эдийн засгийн асуудал. Тавдугаарт: аюулгүй байдлын асуудал. Зургаадугаарт: дипломат харилцааны тухай асуудал. Энэ зургаа дээр бид цаашдаа анализ хийхдээ тулгуурлаж явах ёстой. Энэ зургаа дээр суурилж байж

энэ манайд ашигтай юу, хэн ялах, ялагдах вэ гэдэг асуудал гарч ирнэ.

Эхлээд, 1991 оны Украин бол байхгүй болсон. Украины дайн яаж шийдэгдэх бол гэдэг нь Европын аюулгүй байдлын тогтолцоо яаж шийдэгдэх вэ гэдгээс хамаарах буюу Европын аюулгүй байдлын тогтолцооны асуудал. Дараа нь Орос, Хятад хоёрын асуудал. Энэ бол бидний хараа салгахгүй байх хэсэг. Энэ хоёрын харилцаанаас бид нарын асуудал байнга хамаарч ирсэн. Өнөөдрийн Оросын байр суурь бол Хятадыг аль болох өөртөө татах, аль болох нөгөө

талын эсрэг турхирах зүйлсийг алхам тутамдаа хийж байгаа. Энэ нь ямар учиртай вэ гэхээр Зөвлөлтийг унагаахад нефтийн доод үнийг 12 долларт барьж байсан. Хятадтай бараа эргэлтийг 200 тэрбум давуулнагэж Оросууд ярьж байгаа. Дараагийнх нь аль алиных нь эрх ашиг хөндөгдсөн учраас нэгдүгээрт Украин, Орос аль аль нь улс төрийн тогтолцооны асуудлаа шийдэх хэрэгтэй. Хоёрдугаарт эдийн засгийн буултуудыг хийх. Эцсийн байдалд газар нутгийн хэмжээнд буулт хийх гэдэг ч юм уу, ийм зүйлүүдээр энэ асуудлаа шийдвэрлэнэ.

**Ц. Цолмон**

ОУХ судлаач, МОСААХ

Вьетнам, Америк хоёрын дайн, Орос, Украины дайн бол өөр өөр хэрэг гэдгийг хэлбэ. Вьетнамд бол Америк ялагдаагүй, Америкийн ард түмэн болиулсан. Одоо Оросын ард түмэн бол болиулахгүй байна. Путин юу гэж шийднэ, тэрийг дагаж байна. Путины илгээлтийг үзэхэд цөмийн зэвсгээ бэлдэж байгаа явдал ажиглагдаж байна лээ. Жилийн өмнө Оросууд цөмийн зэвсэг хэрэглэх үү гэдэг асуудалд бүх хүн үгүй гэж байсан бол өнөөдөр бүгд энэ асуудлыг ямар нэгэн байдлаар ярьж байгаа. Нэгдүгээрт, айлгах гэж хийсэн байж болно. Хэрвээ

Оросыг задрахад хүрэх юм бол Монголчуудын хэлдгээр үхэхдээ үхэр буугаа тавина гэгчээр юу ч болж мэднэ. Цөмийн зэвсэг бол Орос задрахад хүрвэл хэрэглэнэ. Оросын задралыг аврахын тулд хэрэглэнэ. Монголтой холбоотой гол нэг асуудал бол Орос задравал яах вэ гэдэг юм. Бид нарын хувьд 100 жилийн өмнөх гашуун түүх байгаа. Одоо Оросод олон хувийн арми байгуулагдаж байна. Өмнөх шигээ улаан, цагаан болж хувирч болно. Өнгөрсөн зуунд аль нь ч Монголд ирсэн эзлээд авчихдаг. Хэрвээ Орос хуваагдаад хоорондоо дайтвал энэ нь

одоогийн Украины дайнаас ч илүү төвөгтэй асуудал гарна. Тэр болгонд манай батлан хамгаалах чадвар бэлэн байна уу. Бид нар одоохондоо эдийн засаг ярьж байгаа боловч Орос ялагдах үед Монголтой маш ойрхон тусна. Цаашлаад цагаачдын асуудал гарна. Монгол язгууртнууд наашаа урсвал яах вэ. Цагаачдын асуудалд бол манайх ямар ч бэлтгэлгүй байгаа. Үүнтэй адил тэрхүү хуваагдлаас ямар зовлон бидэнд ирэх вэ гэдгийг судлах хэрэгтэй.

**О.Машбат**

АБ судлаач, АБХ

Дэлхийн дайн гэдгээр нь харвал Украины дайныг цэрэг-улс төр, эдийн засгийн талаасаа гэсэн өөр өөр /dimension/ хэмжээт өрнөж буй үйл явцууд гэж үзэж хараанаасаа салгахгүй байх чухал. Үүнээс хамгийн аюултай хэд хэдэн зүйлс нь эдийн засаг дотроо байгаад байгаа. Нэгдүгээрт, нийлүүлэлтийн гинжин хэлхээний асуудал тасалдах шинжтэй болно. Дээрээс нь мөнгөний тухай асуудлыг бид хөндөж байх ёстой болж байна. Бас өөр нэг зүйл бол кибер орон зайн тухай асуудал буюу Метаверсе гэдэг маань юу болсон бэ гэдэг. Кибер мөнгө хаашаа алга болсон бэ гэдгийг харж байхгүй бол болохгүй зүйлс гараад байх шиг байна. Ерөнхийдөө миний ойлгож байгаагаар кибер орон зайд, кибер мөнгөний тухайд Америкууд Хятадуудад тавиулчих шиг боллоо. Бусад орон зайн хувьд Америкууд харьцангуй тогтвортой байгаад байх шиг буюу бусад хэмжээт өрнөж буй өрсөлдөөнд Америк тогтвортой байгаа юм шиг харагдаад байна.

Энэ дайн яаж дуусах вэ гэдэг дээр сценариудаа сайн бодох хэрэгтэй. Бидний хувьд буюу Монгол улсын хувьд хамгийн ашигтай нь магадгүй Солонгосын дайны төгсгөл шиг Орос-

Украины дайн төгсөж магадгүй. Аль аль нь өөрсдийн байр суурийг өөр өөрийн хил дээр хадгалаад дуусах. Ер нь бол яг одоогийн байдлаар энэ дайныг яаж дуусгах вэ буюу “End State” яг дайныг ингээд дуусгана гэдгээ дахин тодорхойлох процесс явж байгаа бол Оросуудын хувьд хэрхэн тодорхойлох нь их хэцүү. Барууны хувьд бол End state нь, нэгдүгээрт Оросыг ялах ёстой, хоёрдугаарт энэ ялалт нь Оросыг цөмийн зэвсэг хэрэглэх хэмжээнд хүргэхгүй байх ёстой. Тэгэхээр энэ нь ямар хэмжээнд байх ёстой вэ, end state-ээ бүрэн тодорхойлж чадаагүй байгаа юм болов уу гэж бодоод байна. Хэрвээ байлдааны ажиллагаа Оросын үндсэн нутаг дэвсгэр рүү шилжвэл буюу 2 сарын 24-нөөс өмнөх хилийн заагийг Украины талаас давбал хязгаарлагдмал хэмжээнд цөмийн зэвсэг хэрэглэх нь тодорхой. Тийм байдалд хүргэхгүйгээр яаж ялах вэ гэдэг нь өрнөдийн толгойны өвчин болоод байгаа юм. Хэрвээ сайнаар бодоод Солонгосын дайн шиг нөхцөл байдлаар гал зогсоох юм бол манай гадаад бодлого ямар байх вэ гэдгээ бид нар тодорхойлох нь зүйтэй. Одоо байгаа чиг шугамаасаа өөрчлөгдөх нь юу л бол. Гэхдээ заавал бодох зүйл нь Хятадын жин нөлөө ихсэх нь гарцаагүй.

Сүүлийн хагас жилийн байдлыг харахад ч гэсэн Монголд үзүүлж буй улс төрийн жин нөлөө хүчтэй болоод эхлэх шиг боллоо. Хоёр улс геополтикийн тогтворгүй үед бид юу хийх хэрэгтэй вэ гэдгээ бодох ёстой болно. Эргээд Буриадаа авах уу гэхээр Буриад манайд ирэхгүй ээ. Хамгийн аюултай нь, Тува нь хүрээд ирнэ гэж яривал бид яах вэ. 300,000 гаруй хүнтэй гэх мэт элдэв зүйлсийг эргүүлж харах шаардлага гараад байх шиг байна. Гэвч энэ бүхэн нь Орос задарсан тохиолдолд. Бид нар маш олон чиглэлээр судлах шаардлагатай. Энэ үед нь бид нар Үндсэн хуулиараа оролдох, магадгүй үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа шинэчлэх гэж яарах, эсвэл ирэх жилийн сонгуульд, намар болох гэж байгаа сонгуульд бэлдэх гэх мэт өөрийнхөө хөлийг дэгээдэж болохгүй санагдаад байгаа юм. Энэ үйл явц маань өөрөө ирэх жилүүдэд Хятад, барууны оролцоог нэмэгдүүлэх эрсдэлтэй хүчин зүйл болно гэдгийг анхаарах нь зүйтэй. Болж өгвөл бид нар дотоод тогтвортой байдлаа хадгалах хэрэгтэй. Эдийн засгийн хувьд бид нар 40%-ийг л хянаж чадна.



**Д.Баярхүү**

ОУХ судлаач, МОСААХ

Украины дайнтай холбоотой хоёр хурал болж байгаа юм байна. Эхнийх нь “Украинд Оросоос бүрэн хэмжээний түрэмгийлэл үйлдсэний 1 жилийн ойд зориулсан элчин сайд нарын өглөөний зоог” гэсэн урилгатай арга хэмжээ байв. ЕХ-ноос Монголд суугаа төлөөлөгчийн газар зохион байгуулсан энэ арга хэмжээнд 13 элчин сайд нь сууж тус бүр Украины дайнтай холбоотой мэдээлэл хийж байна. Бүгд мэдээж Орос олон улсын эрх зүйг зөрчлөө, түрэмгийлэл үйлдлээ, НҮБ-ын суурь зарчмыг зөрчлөө гэж байв. Монголтой холбоотой асуудал дээр элчин сайд нар манай нөхцөл байдал, байр суурийг маш сайн ойлгодог юм байна гэж ойлголоо. Тэр нь юу гэхээр Орос, Хятадын дунд хавчигдсан, Оросоос асар их хамааралтай Монгол улс өнөөдөр төвийг сахиад байж байгаа нь өөрөө том ач холбогдолтой юм. Заавал өрнөдийнхөнтэй нийлээд Оросыг буруутгаад бай гэж хэлсэнгүй. НҮБ-д 6 удаа түдгэлзсэн явдал нь зөв, үүнээс өөр арга байхгүй гэдгийг ойлгож байна гэдгийг та бүхэнд хэлье. Оросууд тактикийн цөмийн зэвсэг хэрэглэж магадгүй гэсэн болгоомжлолоор ярьж, тайлбарлаж байна. Яг үнэндээ сүүлийн 30 гаруй жилийн түүхийг үзэхэд, 91 онд ЗХУ тарснаас хойш ОХУ өнөөдрийг хүртэл цөмийн зэвсэг хөгжүүлэх ямар ч программ хэрэгжүүлээгүй юм байна. Цөмийн зэвсгийг байнд нь хүргэх шинэ төрлийн пуужин үйлдвэрлээгүй юм байна. “Сармат” гэгдэх пуужин бол “Сатана” гэж Украинд үйлдвэрлэсэн стратегийн довтолгооны зэвсгийн зөөгч пуужин. Өнгө будгийг нь

сайжруулснаас өөр ямар ч өөрчлөлт мэдрэгдсэнгүй гэнэ. 2014 он хүртэл Украины цөмийн зэвсгийн мэргэжилтнүүд Орост уригдан очиж цөмийн пуужинг засах сэлбэх, цэнэглэх, өөр бусад үйлчилгээний бүх ажлыг хийж байгаад Крым алдагдах үед ажил нь зогссон. Ингээд 9 дэх жилдээ Орос пуужингуудаа сайжруулж чадаагүй. Тэр нь сая Байдэн Киевд очих үед хоёр Сармат пуужин туршсан чинь нэг нь хөөргөсөн суурин дээрээ эргээд буусан. Тэгэхээр энэ байдлаараа бол Орос цөмийн дайнд бэлэн биш. Бараг байхгүй. Москвад батлан хамгаалахын жанжин штабын дээвэр дээр тавьсан агаарын довтолгооноос хамгаалах Панцирь гэхэд тоглоомон зэвсэг. Армийн залуу сурагчдад зориулсан тоглоомон зэвсэг. Оросын КГБ-ын хурандаа байсан хүний яриагаар бол цэрэг-аж үйлдвэрийн 50% нь fake юм. Дандаа хулгайлаад идсэн, худалдсан. Тиймээс Орос тактикийн зэвсэг хэрэглэнэ гэдэг нь Украин болон барууны талын хувьд айдастай зүйл биш. Хятад энэ дайны асуудлаар ам нь таг чиг үдээтэй байж байгаад яг энэ 1 жилийн босгон дээр 12 зүйлт саналаа тавиад хэрэг дээрээ Оросын талд орсон. Энэ санал дотор авах зүйл ч бий, хаях зүйл ч бий. Бодит байдлыг харгалзаад Оросын нэр нүүрийг хадгалж үлдэх гэсэн, айдас шингэсэн санал гэж Украины Ерөнхийлөгчийн тамгын газар, НАТО, ЕХ ч гэсэн ийм дүгнэлтэд хүрээд Хятадын саналыг хэрэгжүүлэх боломж байхгүй, бодит төвөлөгөө биш гэж дүгнэсэн. Энэ нэг жилийн ой дээр Украины дайны асуудлууд дээр Хятад, Оросын байр

суурийн огтлолцол нэг болоод энэ дайны буруутныг тодруулах, буруутнаар АНУ, НАТО-г тодруулах зам руу орлоо. Хятад олон улсын харилцаанд шударга ёс хэмээн ам дагуулж ярьдаг ч цаанаа бол Оросын сонирхолыг хамгаалж байна.

Энэ дайнд Путин ялагдах цаг үе дөхөж байгаа. Путиныг Оросууд нь яаж золигт гаргах нь мэдэгдэхгүй байна. Хрушев шиг гэнэт төрийн эргэлт хийгээд Путиныг буулгаад санкцаа султгая гэх юм бол Хятадад том аюул болно. Учир нь Хятад ганцаараа АНУ-тай тулгараад үлдэнэ. Халз тулаанд Хятадад хань болох хүн байхгүй болох юм. Өнөөдөр Хятад бол үндсэндээ Оросыг вассал / Vassal / маягийн болгочихсон байгаа. Нэгдэж нягтарсан баруунтай Хятад ганцаараа яах юм бэ. Сая Лукашенког аваачиж өндөр дээд түвшинд хүлээн авлаа. Азербайжаний ЗГХЭГ-ын дарга байж байгаад АНУ-д зугтан гарсан Рамизов Украинтай ШХАБ-ын гурван үндсэн улс байлдаж байна гэж хэлж байсан. Тэр гурав нь Орос, Беларус, Иран гурав юм. Одоо Хятад нэмэгдэх нь л дээ. ОХУ-ын Гадаад явдлын яамны дэд сайдаас бидэнд өгсөн анхааруулга байгаа шүү дээ. Гуравдагч хөршөөсөө болгоомжлоорой. Тэдний ов зальд орохгүй байх ухаан Монголчуудад бий шүү гэж анхааруулсан. Яг энэ анхааруулга чинь ШХАБ дээр тулаад ирлээ. Хэрвээ жинхэнэ гишүүн нь байсан бол Шанхайн үзэл санааны дагуу гуравдагч хөршөөсөө салчихсан, АНУ-тай Стратегийн түншлэлийн харилцаа байгуулж чадаагүй, Япон, Өмнөд Солонгос, Энэтхэг,

ЕХ-той харилцаж чадахгүй байх байсан гэж судлаачийн хувьд үзэж байна. ШХАБ ч бай, Евразийн эдийн засгийн холбоо ч бай, Оросын толгойлдог олон улсын ямар ч хамтын нийгэмлэг байсан дайны хөлд чирэгдэнэ. Саяхан Төв Азийн 5+1 уулзалт хийлээшүү дээ. Энэ юу харагдаж байна вэ гэхээр Евразийн эдийн засгийн холбоо нурах гэж байна. Өнөөдөр Казахстаны парламент дээр улс төрийн нэг намын толгойлогч нь Казахстан ЕХ-нд элсэнэ гээд ярьж байна. Энэ хоосон үг биш. Европийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны

бага хурлын гишүүн нь Казахстан. Энэ бүгдийг бид нар тусгаж аваад гадаад бодлого дээрээ хэрэгжүүлэх, Оросоос айж, царайчилж, эсвэл гуравдагч хөрштэй явуулж буй хамтын ажиллагаагаа аль болох зөөлөн харагдуулахыг бодож тайлбарлаж явах юм уу, эсвэл зоригтойхон дуугарах юм уу. Саяхан манай Гадаад харилцааны сайд Мюнхены бага хуралд оролцоод АНУ, барууны гадаад хэргийн сайд нартай уулзаад 6-р сард болох гэж байгаа эмэгтэй гадаад хэргийн сайд нарын анхдугаар

форум Улаанбаатар хотод зохион байгуулах гэж байна гэж мэдэгдсэн. Ихэнх нь барууныхан байгаа. Ямар тоглолт хийхийг бидний ухаан л мэдэх гээд байна л даа. Нийгмийн уур амьсгалын хувьд Орос ялагдвал Хятадад эзлэгдэнэ гэсэн айдас байна. Түрүүн Чехийн элчин сайд хэлж байна лээ. Энэ Оросын суртал нэвтрүүлгийн эзлэн түрэмгийлэл бол дэлхийгээр тарсан. Оросууд оюун санааны эзлэн түрэмгийлэл үйлдэж байна гэсэн. Энэ бүхнийг бид нар анхаарах хэрэгтэй байна.

### Comparison of the military capabilities of NATO and Russia as of 2023

Characteristic	NATO	Russia
<b>Personnel</b>	-	-
Total military personnel	5,817,100	1,330,900
Active soldiers	3,358,000	830,900
Reserve forces	1,720,700	250,000
Paramilitary units	738,400	250,000
<b>Air Force</b>	-	-
Total aircraft	20,633	4,182
Fighters / interceptors	3,398	773
Ground attack aircraft	1,108	744
Transport aircraft	1,506	444
Special aircraft (e.g reconnaissance)	970	147
Tanker aircraft	615	19
Total helicopters	8,614	1,531

Эх сурвалж: <https://www.statista.com/>

**Д.Уламбаяр**

ОУХ судлаач, МОСААХ

Олон туйлт дэлхийн дэг журам гээд Хятад, Оросын толгойлсон хэсэг улс их ярьж байгаа боловч Орос-Украины дайны улмаас олон туйлт дэг журам өөрөө ганхаж эхэллээ. Үүний нэг гол институт болсон ТУХН-ээс Молдав гарах асуудал яригдаж байна. ШХАБ-ыг бол олон туйлт дэг журмын гол тулгуур багана гэж Орос, Хятад хоёр Москвагийн тунхаглал дээр тэмдэглэж байсан. ШХАБ өөрөө их зөрчилтэй боллоо. Евразийн эдийн засгийн холбоо бол зөвхөн Оросод ашигтай, Төв Азийн орнуудад маш их алдагдалтай гэдэг нь тодорхой боллоо. ОДКБ-ын хувьд бол Армен гишүүн гэхэд ямар ч тусламж авч чадаагүй гэдгээ хэлж байх жишээтэй. Тэгэхээр олон туйлт дэг журам гэдэг өөрөө их эргэлзээтэй болж ирж байна. Дараагийнх нь Монгол улстай холбоотой, манай түдгэлзсэн байр суурийн асуудал байгаа юм. Үүнийг манай телевиз, хэвлэл мэдээллийнхэн маш буруу бичиж байна. Abstention буюу НҮБ-ын санал хураалтад оролцоод, түдгэлзсэн санал өгснийг санал хураалтад оролцохоос түдгэлзсэн гэдэг маягаар буруу орчуулаад иргэдийг төөрөгдүүлж байна. 1961 онд Монгол Улсыг НҮБ-д элсүүлэхэд АНУ-ын байнгын төлөөлөгчийн орлогч хэлж байсан. АНУ бол Монгол Улсыг НҮБ-д элсэхэд ямар нэг байдлаар саад хийхгүй. Ийм учраас бид нар замыг нь засахын тулд түдгэлзсэн санал өгнө гээд түдгэлзсэн санал өгч, санал хураалтад БНХУ буюу одоогийн Тайвань санал хураалтад оролцолгүйгээр бид нар НҮБ-д гишүүнээр элсэх сайхан боломж бүрдэж байсан.

Тэгэхээр түдгэлзсэн санал гэдэг бол бие даасан санал. АНУ, ОХУ-г дагаад байгаа юм биш. Үүнийг буруугаар ойлгоод Монгол 6 удаа түдгэлзсэн, удахгүй барууны эдийн засгийн хоригт орж магадгүй гэж УИХ-ын нэг гишүүн ярьж байна шүү дээ. Гэтэл ЕХ, сая АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын орлогч ирж, хамтарсан мэдэгдэл гаргасан. Үүнд бид нар Монголын газарзүйн онцлогийг гүнээ ойлгож байгаа гэдэг байр суурийг илэрхийлсэн. Бид нар ардчилалаас ухраагүй учраас энийг сайн анхаарах хэрэгтэй. Дайны төгсгөлийн асуудлаар хэлэхэд, 9-р сарын 30-нд Украины 4 муж улсыг ОХУ-ын бүрэлдэхүүн гэж холбооны хурлаараа батлаад Путин гарын үсэг зурсан. Нөгөө тал нь энэ 4 нутгаа эргүүлж авах, тэр ч бүү хэл Крымыг эргүүлж авах хүртэл дайн үргэлжлэнэ гээд буй. Энхтайвныг газар нутгаараа наймаалцахгүй, тэгэх юм бол Пандорагийн хайрцаг нээгдэнэ гэх мэтчилэн яриад байна. Мөн Орос хуулиа хүчингүй болговол, Орос ялагдвал Путины төгсгөл ирнэ гэж яриад байна. Одоогоор ийм нөхцөл харагдахгүй байгаа болохоор энэ дайны төгсгөл тийм ойрхон харагдаж байна уу гэдэг асуудал ихээхэн эргэлзээтэй. Дараагийн асуудал бол Орос, Хятадын харилцаа юм. Сая Мюнхений бага хурал дээр манай Гадаад харилцааны сайдтай ХКН-ын Улс төрийн товчооны гишүүн Ван И уулзсан. 2-3 хоногийн дараа Синхуа агентлагийн мэдээ гарсан. Монгол улстай Хятад улс бүс нутгийн болон олон улсын тавцанд гадаад бодлогоо уялдуулан зохицуулна гэж

уг мэдээнд тэмдэглэсэн. Өнгөрсөн жил 6-р сард Лавров Монголд айлчлахад манай талын мэдэгдэлд ийм зүйл огт байхгүй байхад Оросын Гадаад харилцааны яамны вэбсайт дээр Монголтой гадаад бодлогын асуудал дээр уялдуулан зохицуулна гэж гарсан. Гадаад бодлогоо уялдуулна гэдэг нь Монгол улс бие даасан гадаад бодлогоо алдах ийм эрсдэл хоёр хөршөөс байнга ирж байгаа нь маш тодорхой харагдаж байна. Энэ нь манай бие даасан, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, үндэсний язгуур эрх ашгаа дээдэлсэн ийм гадаад бодлоготой үндсэндээ зөрчилдөж байна гэж ойлгож байна.

Хамгийн гол зүйл бол Орос аюулгүй байдал нь “хүзүүн дээр хутга тулгасан” үед цэргийн тусгай ажиллагааг эхэлсэн гэж мэдэгдсэн ч нэг жилийн дараа харахад Оросын аюулгүй байдал баталгаажсан уу гэдэг нь их эргэлзээтэй. Яагаад гэвэл ОХУ Баруун Европын 150 миллиард еврогийн байгалийн хийн зах зээлээ эргэлт буцалтгүй алдлаа. 2022 онд Путин 100 нас хүрээд нас барлаа гэхэд 30 жил өнгөрөх нь, энэ хугацаанд эдийн засаг нь аль хэр сэргэсэн байх вэ гэдэг асуудал их хэцүү боллоо. Сая НҮБ-ын хурал дээр Байнгын төлөөлөгч Небензя ярьж байна. Энэ дайн бол бидний амьд үлдэх эсэхтэй хамаатай гэж. Энэ бол ихээхэн сонин байр суурь харагдаж байгаа юм. Тэгэхээр манай албан ёсны байр суурь бол түдгэлзээд, ямар ч тохиолдолд хүч хэрэглэхийг дэмжихгүй, олон улсын эрх зүйн үндсэн зарчмаа баримтлана гээд ердийн ухамсарын түвшинд болоод ардчилсан улсын хувьд хэн ч,

алийг нь ч шүүмжлэх нь Монгол улсын хувьд нээлттэй гэдгийг харуулж байна.

Дараагийн асуудал бол дайн гарч байгаагийн учир шалтгаан юм. Нэг хүнд эрх мэдэл төвлөрөх, хугацаагүй улс орныг удирдах гэдэг өнцгөөс үүнийг харах хэрэгтэй. Хоёр хөрш бол яг ийм байна. Нөгөө өнцгөөс харахад Орос бол хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнуудтай 30 жилийн турш маргаантай байсан ба нөлөөний хүрээгээ алдахгүйн төлөө тэмцэж байна. Хятадын талын гол асуудал бол Украины нутгаас Оросын цэргийг гаргах гэдгийг огт хөндөхгүй байна. Нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс орны бүрэн эрхт байдал гэдгийг нэр ус заагаагүй хөндсөн нь ихээхэн дэвшил гэсэн өнгө аястай юм ярьж байна. Давхар стандарт буюу нэг талыг барьсан хориг арга хэмжээ авч, нэг талыг барьж зэвсэг, техник нийлүүлж байна

гэж байна. Хятадын ийм байр суурь асуудлыг шийдвэрлэхэд хоёрдмол хандлага бий болгож байна. Энхбаяр докторын хэлснээр Орос цэргээ гаргачих юм бол эдийн засгийн гол хориг арга хэмжээ сулрах магадлалтай. Тэгэхээр өнөөдрийн өнцгөөс харвал дайн дуусах ойрын төлөв байдал төдийлөн харагдаж өгөхгүй байна. НАТО Оросын зүг өргөжихгүй гэсэн ямар ч баримт бичиг байхгүй. 1987 оны 5-р сард хуралдаж Оростой байгуулсан Founding act буюу суурь баримт бичиг дээр бол энэ талаар тохиролцоогүй. Путины үед 2004 онд НАТО хамгийн ихээр өргөжиж 10 гишүүн элсүүлсэн. Балтийн 3 улстай Орос аль хэдийнээс хил залгаатай учраас НАТО Дорно зүг өргөжих гэдэг нь үнэмшилтэй биш байна. Оросын зорилго нэлээд өөрчлөгдсөн. Эхлээд Донецк, Луганск бүсүүдэд ЗД үйл ажиллагаа буюу цэрэггүй бүс болгох, үндэсний үзэлгүй болгох

гээд явсаар байгаад сүүлдээ НАТО болж ирээд 4 мужийг өөрийн болгосон. Энэ нь олон улсын эрх зүй, дэлхийн практикт байгаагүй үйл явдал боллоо. Одоогийн гол зорилго бол олон улсын хууль дүрэмд суурилсан дэлхийн дэг журам, ардчиллыг эрхэмлэсэн дэг журам дээрээ хатуу зогсох хэрэгтэй гэдэг байр суурь байгаа юм. Эцэст нь хэлэхэд гадаад бодлогоо хоёр хөрштэйгөө уялдуулна, зохицуулна гэж Хүйтэн дайны үе рүүгээ орохгүй, бие даасан гадаад бодлого явуулна. Тийм учраас бид нар хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцахын зэрэгцээ гуравдагч хөрштэйгөө харилцаж энэ хоёрын дунд стратегийн эрх ашгийн тэнцвэрээ сайн хангах асуудал байгаа юм. Эрх мэдлийг нэг хүнд өгөх нь ямар ч тохиолдолд байж болохгүй юм байна гэдгийг энэ бүхэн харуулж байна.



**Ж.Гөлгөө***Олон улсын харилцааны судлаач*

Swift олон улсын төлбөр тооцооны систем бол одоогоос 4-5 жилийн өмнө дэлхийн худалдааны үндсэн бараа солилцооноос бусад бүх хэлбэрийг хамарч байсан. Гэтэл Хятад, АНУ-ын өрсөлдөөн болж Хятадын эдийн засаг давамгайлаад эхлэхээр Хятад өөрсдийн хил дамнасан тооцооны системийг сүүлийн 3-4 жил хэрэгжүүлээд, Иран мэтийн АНУ-ын эсрэг орнуудыг оруулсан. Нөгөө талаас Орос өөрсдийн валютын ханшийг хадгалахын тулд нэг хэсэг Европын орнууд руу нефть, хийг рублиэр худалдсан нь Америк доллар зохих хэмжээгээр хасагдахад хүргэсэн. Евро-эдийн засгийн хүрээнд өөрийн валюттай болох асуудал яригдаж байна. АНУ-ын эдийн засаг сүүлийн үед зээл нь байх хэмжээнээсээ өсөөд төрийн

зээллэг маш их болж унаж байна. Энэ байдлаараа АНУ-ын доллар цаашид ч хумигдаад дэлхийд региалны чанартай төлбөр тооцооны систем гарч ирэх хандлагууд байна. Өөрөөр хэлбэл улс төрийн нөлөө тооцооны системд бас нөлөөлдөг байна гэх хандлагууд цаашдаа үргэлжлэх байх гэсэн ойлголт байна.

ОХУ рублийн ханшийг хадгалж чадсан нь зөвхөн алттай холбоотой биш. Оросын засгийн газар хэд хэдэн үр дүнтэй арга хэмжээ авсантай холбоотой. Төв банкны бодлогын асуудал байна. Хоёрдугаарт дотооддоо засгийн газрын зээлийг хэрэгжүүлж, гадагшаа гарах валютын урсгалыг зогсоосон, төсвийн алдагдлыг нөхөхийн тулд үндэсний баялгийн санг ашигласан гэх мэт. Орос бол

валютын нөөц ихтэй. Алт бол олон улсын төлбөр тооцоонд нөлөөлөх гэхээс урьтаад хамгийн найдвартай гэдэг утгаараа найдвартай байх. Миний дээр дурдсанчлан долларын олон улсын валютын ач холбогдол унаад Хятадын систем бий болж, Оросууд болвол Арабын орнууд, Энэтхэгтэй рублиэр тооцоо хийгээд эхлэхээр байдал өөр болж болох юм. Гэвч өөр өөр валют ашиглаж байгаагийн цаана хамгийн баталгаатай нь алт байгаа шүү гэх ойлголт хэвээр учраас алт бол алсын баталгаа болохоос биш алттай холбоотой асуудлаас үндсэндээ шалтгаалаад рублийн ханшийг тогтвортой барьж чадсан гэх нь учир дутагдалтай гэж санагдаж байна.

**Н.Энхбаяр***ССХ, судлаач*

ОХУ-ын алтны нөөц 2020 оноос хойш 3 жил дарааллаад 2298 тонн буюу яг энэ түвшинд байна. Өөр нэг улс яг ийм байдалд орлоо гээд валютын нөөцөө алттай уялаа гэж бодоход магадгүй алтаар тодорхой худалдаа, төлбөр тооцоо хийж болно. Гэвч одоогийн нөхцөлд дэлхийн санхүүгийн төв болж байгаа Нью-Йорк, Лондон гм. өрнөдийн том хотууд, тэднийг удирдаж буй улс орнууд бүгд хориг тавьж байгаа учраас алт төлбөрийн хэрэгсэл болох магадлал тун бага. Эцсийн мөчид ОХУ-тай худалдаа хийж буй Энэтхэг, Хятад улсууд тооцоо хийж магадгүй. Өрнөдийн орнууд ОХУ-аас алт авах бололцоо байхгүй. Нэмээд хэлэхэд Монгол улсын анхаарах ёстой зүйл бол

НҮБ-ын худалдаа, хөгжлийн байгууллагаас гаргасан түүхий эдийн хамааралт байдлын улс орнуудын судалгаан дотор Монгол улс 2021 оны байдлаар 97% байдаг. 94% уул уурхай, 3% ХАА-н түүхий эд. 95%-иас дээш хамааралтай улс орнууд хэд байна, 90-ээс дээш хэдэн улс байна вэ гэхээр 3-4 Африкийн хэдэн улс байгаа юм. Түүхий эдээс өндөр хамааралтай Австрали, Чили улс 70%-аас доогуур. Монгол улс түүхий эдээс маш өндөр хамааралтай. Жилийн экспортын 40% нь нүүрс, 32% нь зэсийн баяжмал, 12% нь төмрийн хүдэр гээд 2-3 түүхий эдээс хамааралтай. Энэ нь гадаад өрсөлдөх чадварын маш том сул тал. Бидний үндэсний аюулгүй байдлын үзэл

баримтлалд байдаг нэг орон зайн худалдаа хамаарал. Гэтэл ОХУ-тай хийж буй худалдаа бага. Хятадын худалдан авалт 90-94% экспортын. Тэгэхээр хойд хөрш хаагдвал худалдааны ганцхан түншээс 90% хамааралтай болж байгаа юм. Нөгөө талд нь энийг зөв ашиглах уу, аядуу байх уу гэдэг нь өөр асуудал. Цаашдаа энэ бол Монгол Улсын хувьд том сорилт. ОХУ-ын эдийн засаг, худалдаа чөлөөтэй болсон хэрнээ урд хөршийн гуравхан боомтоор бүх ажлаа /12 тэрбум долларын экспорт/ хийж байна. Замын үүд, Гашуунсухайт, Шивээ хүрэн боомтууд дээр ямар нэгэн түгжрэл үүсэхэд бид нар импортын хувьд гарцгүй байгаа шүү гэдгийг сануулья.